



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/32/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН  
ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Ахлах аудитор Ц.Саранчимэг

Утас: 70273204 Цахим хаяг: [tsaranchimeg@audit.gov.mn](mailto:tsaranchimeg@audit.gov.mn)

## Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	15
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
4.1 Залруулсан алдаа .....	17
4.4 Зөвлөмж .....	18

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
ЗГХА	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
ГБХЗХГ	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг  
Утас: 70272248, Факс: 70272582, Имэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 0160  
танай -ны № -т

**Зөрчилгүй дүгнэлт**

ТӨВ АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД  
ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ДАРГА Д.БАДАМЦЭЦЭГ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Төв аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

**19020248**

D 2022/2022 он/ALBAN BICHIG

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>28,497,962.59</b>	<b>48,033,447.53</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	180,000.00	7,598,950.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	180,000.00	180,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	7,418,950.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	28,317,962.59	40,434,497.53
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	00.00	14,049,000.00
35110	Тусгай зориулалттай материал	00.00	14,049,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	28,317,962.59	26,385,497.53
35410	Бичиг хэргийн материал	00.00	1,044,200.00
35420	Аж ахуйн материал	28,317,962.59	23,760,047.53
35440	Түлш, шатах тослох материал	00.00	1,581,250.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,811,365,837.88</b>	<b>1,718,624,323.82</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,811,365,837.88	1,718,624,323.82
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,754,489,171.30	1,662,164,323.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,787,363,920.24	1,787,363,920.24
39202	Хуримтлагдсан элэгдэл	-221,280,694.56	-303,008,544.72
39203	Авто-тээврийн хэрэгсэл	30,000,000.00	30,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-6,941,666.47	-10,104,166.39
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	341,428,575.73	396,106,128.73
39206	Хуримтлагдсан элэгдэл	-222,365,202.88	-271,086,956.88
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	111,538,157.01	111,538,157.01
39208	Хуримтлагдсан элэгдэл	-65,253,917.77	-78,644,214.17
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	56,876,666.58	56,460,000.00
39301	Програм хангамж	3,952,468.70	3,952,468.70
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,535,802.12	-3,952,468.70
39303	Бусад биет бус хөрөнгө	56,460,000.00	56,460,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,839,863,800.47</b>	<b>1,766,657,771.35</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,839,778,582.64</b>	<b>1,766,657,771.35</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,839,778,582.64	1,766,657,771.35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,070,976,822.90	1,070,976,822.90
51101	Өмч: - төрийн	1,070,976,822.90	1,070,976,822.90
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	768,073,441.08	694,952,629.79
51210	Өмнөх үеийн үр дүн	768,073,441.08	768,073,441.08
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-73,120,811.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	728,318.66	728,318.66
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,839,863,800.47</b>	<b>1,766,657,771.35</b>

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>601,700,629.40</b>	<b>617,933,933.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>17,902,780.40</b>	<b>54,927,553.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	17,902,780.40	54,927,553.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,902,780.40	54,927,553.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	17,767,780.40	54,927,553.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>583,797,849.00</b>	<b>563,006,380.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	360,765,700.00	295,642,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	360,765,700.00	295,642,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	30,906,549.00	49,042,580.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод	6,973,829.00	32,074,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон	23,932,720.00	16,968,580.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	192,125,600.00	218,321,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	192,125,600.00	218,321,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>746,456,662.84</b>	<b>691,054,744.29</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>746,456,662.84</b>	<b>691,054,744.29</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	677,432,073.88	647,384,313.27
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	151,175,333.93	134,883,515.00
210101	Үндсэн цалин	104,099,394.54	97,278,291.90
210102	Нэмэгдэл	25,998,388.21	30,476,635.51
210105	Гэрээт ажлын хөлс	21,077,551.18	7,128,587.59
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	21,365,993.41	18,608,638.45
210201	Тэтгэврийн даатгал	21,365,993.41	12,849,989.83
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	1,322,441.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	951,423.34
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	940,552.58
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	2,544,231.48
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	212,883,243.40	216,075,089.40
210301	Гэрэл, цахилгаан	7,440,309.00	6,190,905.00
210302	Түлш, халаалт	201,344,246.40	201,346,282.40
210303	Цэвэр, бохир ус	4,098,688.00	8,537,902.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,715,870.30	11,147,305.06
210401	Бичиг хэрэг	3,271,340.00	2,075,420.00
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.00	1,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,360,170.30	817,690.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	550,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	734,360.00	446,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	6,168,195.06
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	2,223,910.00	390,650.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,223,910.00	390,650.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	80,000.00	572,000.00
210702	Дотоод албан томилолт	80,000.00	572,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	116,443,226.83	115,579,548.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	114,455,429.83	113,517,251.30
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	806,400.00	696,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	85,564.00	87,744.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	517,000.00	541,330.00
210807	Газрын төлбөр	223,833.00	382,223.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	165,034,196.01	150,127,567.06
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,273,600.00	2,708,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	161,610,596.01	147,419,067.06
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	69,024,588.96	43,670,431.02
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	66,729,523.22	43,670,431.02
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	66,729,523.22	43,670,431.02
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-144,756,033.44</b>	<b>-73,120,811.29</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-144,756,033.44</b>	<b>-73,120,811.29</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	/ төгрөгөөр /
						Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,070,976,822.90</b>	<b>728,318.66</b>	<b>768,073,441.08</b>	<b>00.00</b>	1,839,778,582.64
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,070,976,822.90</b>	<b>728,318.66</b>	<b>768,073,441.08</b>	<b>00.00</b>	1,839,778,582.64
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,070,976,822.90</b>	<b>728,318.66</b>	<b>768,073,441.08</b>	<b>00.00</b>	1,839,778,582.64
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-73,120,811.29	00.00	-73,120,811.29
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,070,976,822.90</b>	<b>728,318.66</b>	<b>694,952,629.79</b>	<b>00.00</b>	1,766,657,771.35

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>583,932,849.00</b>	<b>563,006,380.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>135,000.00</b>	<b>00.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	135,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	135,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	135,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>583,797,849.00</b>	<b>563,006,380.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>360,765,700.00</b>	<b>295,642,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	360,765,700.00	295,642,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>30,906,549.00</b>	<b>49,042,580.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс	6,973,829.00	32,074,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	23,932,720.00	16,968,580.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>192,125,600.00</b>	<b>218,321,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	192,125,600.00	218,321,400.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>583,932,849.00</b>	<b>563,006,380.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>583,932,849.00</b>	<b>563,006,380.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>514,908,260.04</b>	<b>511,916,998.98</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>151,175,333.93</b>	<b>151,569,644.53</b>
210101	Үндсэн цалин	104,099,394.54	97,555,671.43
210102	Нэмэгдэл	25,998,388.21	30,476,635.51
210105	Гэрээт ажлын хөлс	21,077,551.18	7,537,337.59
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>21,365,993.41</b>	<b>17,922,508.92</b>
210201	Тэтгэврийн даатгал	16,009,179.85	12,760,260.11
210202	Тэтгэмжийн даатгал	1,384,863.37	1,322,441.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,087,090.69	1,041,153.06
210204	Ажилгүйдлийн даатгал	271,372.72	254,423.05
210205	Эрүүл мэндийн даатгал	2,613,486.78	2,544,231.48
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>212,883,243.40</b>	<b>216,075,089.40</b>
210301	Гэрэл, цахилгаан	11,031,050.00	6,190,905.00
210302	Түлш, халаалт	195,996,637.40	199,680,126.40
210303	Цэвэр, бохир ус	5,855,556.00	10,204,058.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,715,870.30</b>	<b>6,420,090.00</b>
210401	Бичиг хэрэг	3,271,340.00	3,029,620.00
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.00	1,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,360,170.30	909,820.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	550,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	734,360.00	440,650.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,323,910.00</b>	<b>396,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,323,910.00	396,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>510,300.00</b>	<b>572,200.00</b>
210604	Урсгал засвар	510,300.00	572,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>80,000.00</b>	<b>572,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	80,000.00	572,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,</b>	<b>116,340,009.00</b>	<b>131,217,401.13</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	114,352,212.00	129,114,234.13
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	806,400.00	696,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	85,564.00	87,744.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	517,000.00	582,200.00
210807	Газрын төлбөр	223,833.00	382,223.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,513,600.00</b>	<b>3,172,065.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,291,600.00	3,172,065.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>69,024,588.96</b>	<b>51,089,381.02</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>458,580.00</b>	<b>00.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	458,580.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>66,729,523.22</b>	<b>51,089,381.02</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох</b>	<b>1,836,485.74</b>	<b>00.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,836,485.74	00.00
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	419,199,900.00	486,161,776.78	513,963,800.00	474,188,280.14
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	419,199,900.00	486,161,776.78	513,963,800.00	474,188,280.14
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	386,356,700.00	485,703,196.78	513,963,800.00	474,188,280.14
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	135,251,200.00	130,097,782.75	135,251,300.00	128,032,306.94
210101	Үндсэн цалин	104,762,500.00	104,099,394.54	104,762,600.00	97,555,671.43
210102	Нэмэгдэл	30,488,700.00	25,998,388.21	30,488,700.00	30,476,635.51
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлбөр</b>	18,258,700.00	17,643,531.33	18,258,900.00	17,060,637.67
210201	Тэтгэврийн даатгал	12,810,373.22	12,286,717.77	12,848,900.00	11,898,388.86
210202	Тэтгэмжийн даатгал	1,384,863.37	1,384,863.37	1,352,500.00	1,322,441.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,087,090.69	1,087,090.69	1,082,000.00	1,041,153.06
210204	Ажилгүйдлийн даатгал	271,372.72	271,372.72	270,500.00	254,423.05
210205	Эрүүл мэндийн даатгал	2,705,000.00	2,613,486.78	2,705,000.00	2,544,231.48
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	217,749,200.00	212,883,243.40	217,749,200.00	216,075,089.40
210301	Гэрэл, цахилгаан	24,000,000.00	11,031,050.00	24,000,000.00	6,190,905.00
210302	Түлш, халаалт	181,749,200.00	195,996,637.40	181,749,200.00	199,680,126.40
210303	Цэвэр, бохир ус	12,000,000.00	5,855,556.00	12,000,000.00	10,204,058.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,136,000.00	6,102,130.30	5,740,000.00	5,349,820.00
210401	Бичиг хэрэг	2,500,000.00	2,500,000.00	2,500,000.00	2,500,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.00	1,800,000.00	1,800,000.00	1,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.00	1,199,170.30	1,200,000.00	809,820.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгч	240,000.00	240,000.00	240,000.00	240,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	00.00	00.00	396,000.00	396,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	00.00	396,000.00	396,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	572,200.00	510,300.00	572,200.00	572,200.00
210604	Урсгал засвар	572,200.00	510,300.00	572,200.00	572,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,749,500.00	80,000.00	1,019,400.00	572,000.00
210702	Дотоод албан томилолт	1,749,500.00	80,000.00	1,019,400.00	572,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ</b>	3,348,200.00	115,094,609.00	131,721,000.00	102,958,161.13
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг	00.00	113,217,212.00	128,372,800.00	100,854,994.13
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тог	696,000.00	696,000.00	696,000.00	696,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	85,564.00	150,000.00	87,744.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,200,000.00	55,000.00	1,200,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	582,200.00	517,000.00	582,200.00	582,200.00
210807	Газрын төлбөр	420,000.00	223,833.00	420,000.00	382,223.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3291700.00	3291600.00	3255800.00	3172065.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,291,700.00	3,291,600.00	3,255,800.00	3,172,065.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	32843200.00	458580.00	0.00	0.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	32,843,200.00	458,580.00	00.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн	32,243,200.00	00.00	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамш	600,000.00	458,580.00	00.00	00.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	554,549,100.00	486,296,776.78	513,963,800.00	513,963,800.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	336,227,700.00	299,099,033.38	295,642,400.00	295,642,400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	336,227,700.00	299,099,033.38	295,642,400.00	295,642,400.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	218,321,400.00	187,197,743.40	218,321,400.00	218,321,400.00
132001	Орон нутгийн төсвөөс	218,321,400.00	187,197,743.40	218,321,400.00	218,321,400.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	12	12	12	12
620002	Гүйцэтгэх ажилтан	4	4	4	4
620003	Үйлчлэх ажилтан	8	8	8	8

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>29,070,063.26</b>	<b>37,728,718.84</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>29,070,063.26</b>	<b>37,728,718.84</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	29,070,063.26	37,728,718.84
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	21,077,551.18	7,537,337.59
210105	Гэрээт ажлын хөлс	21,077,551.18	7,537,337.59
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	3,722,462.08	861,871.25
210201	Тэтгэврийн даатгал	3,722,462.08	861,871.25
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,613,740.00	1,070,270.00
210401	Бичиг хэрэг	771,340.00	529,620.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	161,000.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	371,400.00	440,650.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,323,910.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,110,400.00	28,259,240.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00	28,259,240.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	222,000.00	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	222,000.00	00.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>29,400,063.26</b>	<b>47,536,094.26</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>29,400,063.26</b>	<b>47,536,094.26</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	32,074,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	23,696,234.26	15,462,094.26
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын, хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой анхан шатны баримтын бүрдүүлэлт болох ө баримт, дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын, хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн №07/13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар нь орон нутагт Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Залуучуудын хөгжлийн тухай хуулийг хэрэгжүүлж, мөрдөж ажиллах мөн хүүхэд залуучуудын хөгжих, оролцох оролцоог нээн хөгжүүлэх, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэд, залуучууд, гэр бүлийг илрүүлж, нөхцөл байдлын үнэлгээ хийж, холбон зуучлах үйлчилгээнд хамруулж, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн байгууллага юм.

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын, хөгжлийн газрын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын, хөгжлийн газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр

дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын, хөгжлийн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын, хөгжлийн газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/58 тоот тушаалаар дотоод хяналт шалгалт явуулах ажлын хэсгийг байгуулж шалгалт явуулах хуваарийг баталсан байна.

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын, хөгжлийн газрын дотоод хяналтын ажлын хэсэг нь 8 хэрэгжүүлэх арга хэмжээний дотоод хяналт хийх төлөвлөгөө гаргасны дагуу шалгалт хийж, шалгалтын дүнг хэлэлцүүлэн илэрсэн зөрчлийг арилгах талаар хугацаатай үүрэг өгч биелэлтийг тооцож ажилласан байна.

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын, хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийгдээгүй, 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийгдсэн байна.

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын, хөгжлийн газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын, хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшин 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 601,700.6 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 9,025.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75,0 хувиар буюу 6,769.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын, хөгжлийн газрын төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мэдээллээр тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос дахин тооцлоо.

Гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин 9,269.0 мянган төгрөг, энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 243.5 мянган төгрөгөөр өссөн байна. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 6,951.8 мянган төгрөгөөр тогтоогдсон байна.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын, хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Монгол Улсын холбогдох хууль, журам, заавар, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын харьяа байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бэлтгэн тайлагнасан байна.

#### ***Орлого:***

Тус байгууллага 2021 онд улсын төсвөөс 295,642.4 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 49,042.6 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 54,927.6 мянган төгрөг нийт 617,933.9 мянган төгрөг, өмнөх оноос 16,233.3 мянган төгрөгөөр буюу 2,7 хувиар өссөн байна.

#### ***Зардал:***

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 691,054.7 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 511,917.0 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 474,188.3 мянган төгрөг зарцуулсан байна.

#### ***Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:***

Тус байгууллага төрийн сангийн 100140017002 тоот дансанд 2021 онд 583,932.8 мянган төгрөгийн орлого, 583,932.8 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Мөн нэмэлт санхүүжилтийн 100140017402 тоот дансанд 49,042.6 мянган төгрөгийн орлого төвлөрч, 49,042.6 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	180.0	7,598.9	7,418.9
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	28,317.9	40,434.5	12,116.6
Үндсэн хөрөнгө	1,811,365.8	1,718,624.3	(92,741.5)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,839,863.7</b>	<b>1,766,657.7</b>	<b>(73,206.0)</b>
Өр төлбөр	85.2	-	(85.2)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,839,778.6	1,766,657.8	(73,120.8)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,839,863.8</b>	<b>1,766,657.8</b>	<b>(73,206.0)</b>

Авлагын дансны үлдэгдэл 7,598.9 мянган төгрөг болж 7,418.9 мянган төгрөгөөр өссөн нь төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогыг татан төвлөрүүлснийг авлагаар бүртгэснээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 40,434.5 мянган төгрөг болж 12,116.6 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал 14,049.0 мянган төгрөгийн дурсгалын зүйл, медаль, эмхэтгэл гаргах материал шилжүүлснээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,718,624.3 мянган төгрөг болж 92,741.5 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдэл зардлаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,766,657.8 мянган төгрөг болж 73,120.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 636,862.3 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 636,862.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 122,898.5 мянган төгрөгөөр бууруулж улс, орон нутгийн төсвөөс 513,963.8 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь Цалин, шимтгэлийн зардал 56,584.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 69,400.6 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 15,362.4 мянган төгрөг бууруулсантай холбоотой байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 513,963.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 295,642.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 218,321.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 295,642.4 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 218,321.4 мянган төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 474,188.3 мянган төгрөгийг зарцуулж, 39,775.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 474,188.3 мянган төгрөг буюу 92,3 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 28,762.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар нь тайлант онд ЗГХА-ГБХЗХГ-аас Орон нутгийн хамтарсан багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд 5,000.0 мянган төгрөг, Залуучуудын хөгжлийн төвүүдийн үйл ажиллагааг дэмжих, үйл ажиллагааны зардалд 7,000.0 мянган төгрөг, Хүчирхийлэл, гэмт хэрэг зөрчлөөс иргэдийг урьдчилан сэргийлэх чиглэлээрх нөлөөллийн арга хэмжээг эрчимжүүлэх зардалд 9,500.0 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангаас Залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэхэд 10,000.0 мянган төгрөг, Хөөрхөн зүрхнүүдийн аян ТББ-аас 250.0 мянган төгрөг, Монгол залуу мэргэжилтнүүдийн нийгэмлэгээс 324.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 16,968.6 мянган төгрөг нийт 49,042.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үүнээс гэрээт ажилтны цалин, шимтгэлд 8,399.2 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 1,070.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 28,259.2 мянган төгрөг, төвлөрүүлэх шилжүүлэг 11,313.9 мянган төгрөг нийт 49,042.6 мянган төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Ковид-19-ын тохиолдол батлагдаж, бүртгэгдсэнтэй холбогдуулан эрсдэлт нөхцөлд байгаа Зуунмод, Алтанбулаг, Жаргалант, Баянцогт, Батсүмбэр сумдын 46 өрхийн 121 хүүхэд, Аргалант, Алтанбулаг, Жаргалант сумдын дотуур байр, гэртээ тусгаарлан ажиглагдаж байгаа болон эмчлэгдэж байгаа 158 хүүхдэд хүнс, ариун цэвэр, амин дэмийн багцуудын тусламж үзүүлсэн байна. Эцэг, эх нь хөл хорионд орж хараа хяналтгүй байсан 3 өрхийн 8 хүүхдэд хүнсний тусламж, ээж нь корона вирус цар тахлын улмаас нас барж хагас өнчин болсон Баянцогт, Батсүмбэр сумдын 8 хүүхдэд сэтгэлзүйн үйлчилгээ, хүнс ариун цэврийн багц, эхийн сүү орлуулагч, живхний тусламж үзүүлсэн. Гамшиг, онцгой нөхцөл дэх үеийн хүүхэд гэр бүлд үзүүлэх хамгааллын хариу үйлчилгээнд нийт 50 өрх, 295 хүүхэд хамрагдаж, 9700.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Төв аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/54 тоот захирамжаар ГБХЗХГ-ын дэргэдэх "Хүүхэд залуучуудын ордон"-ы орон тоог техникч 1, үйлчлэгч 3, нийт 4 орон тоогоор, цалингийн санг 27,675.0 мянган төгрөгөөр, өөрийн орлогыг 6,480.0 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд түрээсийн орлогоор 16,968.6 мянган төгрөг зарцуулж тухай бүр төрийн санд хүсэлт гаргаж, цалингийн зардалд зарцуулсан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 129,114.2 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүнд: 7 удаагийн сургалтад 17,465.0 мянган төгрөгийн сургагч багшийн цагийн хөлсний төлбөрийг гэрээний дагуу олгосон байна. Гэрээт цагийн хөлсийг тогтоосон 50.0-200.0 мянган төгрөгөөр тооцож гэрээ байгуулан гүйцэтгэлээр нь олгосон байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 143 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 6 байна. Тус байгууллага Шилэн дансны хуулийн дагуу байршуулах мэдээллээс 13,495.0 мянган төгрөгийн 10 шийдвэрийг байршуулаагүй байна. Мөн бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний 7 буюу 17,465.0 мянган төгрөгийн гэрээг байршуулаагүй байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар нь нэмэлт санхүүжилтийн дансаар зарцуулсан 49,42.6 мянган төгрөгийг бусад хууль тогтоомжийн хүрээнд зарцуулан тайлагнасан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар ХХОАТ-ын дундын суутгал хийж төсөвт төвлөрүүлж байх, байгууллагаас зохион байгуулж байгаа арга хэмжээг аль болох хямд зардлаар, үр ашигтай явуулж байхад анхаарах, төсвийг бодитой төлөвлөх, түрээсийн гэрээг нарийвчлан гаргаж, баталгаажуулах зэрэг 4 зөвлөмжийг 100.0% хэрэгжүүлэн ажиллаж Төв аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын, хөгжлийн газрын даргын 2021 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 07/113 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас гаргаж буй гэрээ хэлцэл, спорт заалны, киноны, хурлын заалны, байрны кафе, сарафан сампин, ТББ, өмгөөлөгч, сургалтын төвүүдэд, бусад түрээсийн гэрээг шилэн дансанд байршуулсан эсэхийг шалгах

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 27,418.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 686.1 мянган төгрөгийн алдааг залруулж, материаллаг 1,900.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, материаллаг бус 24,832.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, дотоод хяналт, шилэн дансны үйл ажиллагааны зөрчилд зөвлөмж өгөв.

##### 4.1 Залруулсан алдаа

Тус байгууллага нь НДШ-ийг ХХОАТ-ын өглөгийн данс руу бичилт хийж дансны бичилтийг 686.1 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн, 39.9 мянган төгрөгийн НДШ-ийн илүү төлөлтийг дансанд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

##### 4.1 Төлбөрийн акт

ГБХЗХГ-ын Залуучуудын хөгжлийн төвийн дээврийн засвар, Солонго цогцолборын заалны засварын зураг төсвийн үнэ 250.0 мянган төгрөгийн зардлыг авлагын дансаар дамжуулалгүй шууд зардалд бичсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийг 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэсний дагуу шийдвэрлэв.

Гэр, бүл, хүүхэд залуучуудын хөгжил, хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэн ажиллаж байгаа хууль, тогтоомж, стандарт, дүрэм, журам олон нийтийн цахим сүлжээнд нээлттэй байхад аймаг сумдын ИТХ, Засаг дарга нарын албан ажлын хэрэгцээнд зориулан гарын авлага 1,650.0 мянган төгрөгөөр бэлтгэж төсвийг үргүй зарцуулж, зориулалт бус зардал гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийг 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэсний дагуу шийдвэрлэв.

## 4.2 Албан шаардлага

Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулганы дүнг/ Татварын Е баримт, Е постын дүнтэй тулгалт хийхэд Е баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс зөрүүтэй байгаа нь нийт 58 байгууллага, иргэний 24,832.7 мянган төгрөгийн е баримтаар нотлогдохгүй дутуу байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалын 5 дахь заалт, Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 6.5-д заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” бол албан шаардлага тогтоох гэсний дагуу шийдвэрлэв.

## 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. *Дотоод хяналттай холбоотой асуудал*

#### 1.1. Илрүүлэлт:

Батлагдсан төлөвлөгөөгөөр 8 ажил төлөвлөсөн ч дотоод хяналт санхүүгийн үйл ажиллагаа, орлого төвлөрөлт, хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт шалгалт хийгээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 4.1-д “Дотоод хяналт шалгалтыг дараахь чиглэлээр зохион байгуулна”, 4.1.5-д “өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

## 1.2. Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 4.1.5-д “өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт” хийх гэсэн чиглэлийн дагуу Дотоод хяналтын ажлын төлөвлөгөөнд орлогын төвлөрүүлэлтийн байдал болон хөрөнгийн тооллого, хөрөнгийн хадгалалт хамгаалалтын байдалд бүртгэлээр тавих хяналт шалгалт руу чиглүүлэн үр дүнтэй ажил зохион байгуулах

### 2.1. Илрүүлэлт:

Шилэн дансны хуулийн дагуу байршуулах мэдээллээс 13,495.0 мянган төгрөгийн 10 шийдвэрийг байршуулаагүй байна. Мөн бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний 7 гэрээ 17,465.0 мянган төгрөгийн гэрээг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

### 2.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалтын хэрэгжүүлж, дотоод хяналтаар мэдээллийг бүрэн мэдээлсэн эсэхэд хяналт тавьж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар	6	27,418.9	1	686.1	2	1,900.0	1	24,832.7	2	0